



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

“ХОРШОО ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГАА, ТҮҮНИЙ ҮР ДҮН, ҮР
НӨЛӨӨ, ЗЭЭЛИЙН ЭРГЭН ТӨЛӨЛТ”-Д
ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ

2025 он



ХХСангийн салбар чиглэл

Аймгийн хэмжээнд 14 сум хоршоог хөгжүүлэх салбар чиглэлийг баталж, Баянхутаг, Галшар, Дэлгэрхаан, Хэрлэн сумд салбар чиглэлийг батлаагүй байна.



Сангийн эх үүсвэр

ХХААХҮ сайдын 2021 оны 12 дугаар сарын 13-ны А/361 дүгээр тушаалаар “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ыг баталж, Хэнтий аймгийн ХХСанд сумдын СХС-аас олгосон 5,433.5 сая төгрөгийн зээл, 2,400.6 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг сангийн хөрөнгийн эх үүсвэрт тооцсон байна.



Сургалт, зөвлөгөөн

Хоршооны болон хоршоог хөгжүүлэх сангийн үйл ажиллагааны талаар хоршоо эрхлэгч иргэдийг чадавхжуулах сургалтыг аймаг, сумын ЗДТГ, ХХААГ-аас 2022-2024 онд 7 удаа, бусад ТББ-аас 8 удаа зохион байгуулсан байна.



Бодлогын баримт бичиг

Аймгийн 2020-2025 оны үндсэн чиглэл, Засаг даргын мөрийн хөтөлбөрт хоршоог хөгжүүлэх талаар зорилт дэвшүүлээгүй, 12 сумын Засаг даргын мөрийн хөтөлбөрт 27 арга хэмжээг тусгаж, 6 сумын Засаг даргын мөрийн хөтөлбөрт хоршоог хөгжүүлэх талаар зорилт тусгаагүй байна.



Үлдэгдэл хөрөнгө

ХХС-ийн 2024 оны санхүүгийн тайланд тусгагдсан зээлийн үлдэгдлийн 42.0% буюу 2,291.5 сая төгрөг нь хэвийн төлөлттэй, 58.0% буюу 3,224.5 сая төгрөгийн зээл нь хугацаа хэтэрсэн байна.



Төсөл сонгон шалгаруулах хороо

Төсөл сонгон шалгаруулах хороог 12 суманд байгуулж, Галшар, Батширээт, Баянмөнх, Баянхутаг, Дэлгэрхаан, Биндэр сум байгуулаагүй

Төсөл сонгон шалгаруулахад 131 төсөл ирүүлснээс шаардлага хангаагүй 24 төслийг буцааж, төсөл сонгон шалгаруулах хороогоор 92 төслийг хэлэлцүүлж, 15 төслийг хэлэлцүүлээгүй байна.

Дархан суманд 2022 онд 90.0 сая төгрөгийн 3 төсөл, Биндэр суманд 2023 онд 12 төсөлд 139.0 сая төгрөгийн зээлийг төсөл сонгон шалгаруулах хороогоор хэлэлцүүлээгүй байна.

Хяналтын зөвлөл

Хяналтын зөвлөлийг 12 суманд байгуулж, Галшар, Батширээт, Баянмөнх, Баянхутаг, Дэлгэрхаан, Биндэр сум байгуулаагүй байна


Батноров, Мөрөн, Цэнхэрмандал, Дархан, Бор-Өндөр, Жаргалтхаан, Норовлин сумдын хяналтын зөвлөл 2022-2024 онд 10 удаа хяналт хийсэн

Сумдын хяналтын зөвлөл нь хоршоог хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд тавих хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.



ХХСан хариуцсан мэргэжилтэн

Сумдад хоршоо хөгжүүлэх сан хариуцсан **22** ажилтны **86%** нь санхүүгийн мэргэжлийн бус, тус ажлыг хавсран гүйцэтгэдэг байна.



ХОРШОО ХӨГЖҮҮЛЭХ САН

Эх үүсвэр

Зарцуулалт



2022 онд

Үлдэгдэл 2,543.5 сая.төг

2023 онд

Үлдэгдэл 1,864.1 сая.төг

2024 онд

Үлдэгдэл 2,546.7 сая.төг



ХХСангаас **2,429.2** сая төгрөгийн **102** төсөлд санхүүжилт олгох сумын Засаг даргын Захирамж гарсан байна. Харин **485.6** сая төгрөгийн **5** төсөлд зээл олгох шийдвэр гараагүй байна.


2022-2024 онд **2,559.2** сая төгрөгийн зээлийг **68** төсөлд олгох төсөл сонгон шалгаруулах хорооны шийдвэр гарч, **1,095.0** сая төгрөгийн **39** төслийн зээлийг хэлэлцээгүй байна.

Зээлийн хороо байгуулсан сум - **12**

Зээлийн хороо байгуулаагүй сум - **6**

Зээлийн хороог буруу байгуулсан - **3**

ХОРШОО ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ЗАРЦУУЛАЛТ
/2022-2024 он/



Бүрэлдэхүүнийг журамд заасны томилоогүй

Дадал сум Төрийн банкны эрхлэгчийг томилсон

Цэнхэрмандал сум ИТХ-ын 3 төлөөлөгчийг томилсон

Дархан сумын Засаг даргын орлогчоор ахлуулсан



2022-2024 онд нийтдээ **14** сумын хоршоо хөгжүүлэх сангаас **59** хоршоо, **44** иргэн, **4** аж ахуйн нэгжид зээл олгосон байна.



Хоршоо

Хэрэгжиж байгаа

45

Хэрэгжээгүй

14

Иргэн

Хэрэгжиж байгаа

30

Хэрэгжээгүй

14

Аж ахуйн нэгж

Хэрэгжиж байгаа



3

Хэрэгжээгүй


1



2022-2024 онд нийтдээ **131** төсөл ирснээс **107** төсөлд **2,914.7** сая төгрөгийн зээл олгосон байна.



ХОРШОО ХӨГЖҮҮЛЭХ САНД ИРСЭН ТӨСЛИЙН ҮР ДҮН






Хоршоо хөгжүүлэх сангийн хяналтын программд сангийн **4,268.6** сая төгрөгийн зээлийг бүртгэсэн бол **1,237.2** сая төгрөгийн зээл бүртгэгдээгүй байна.

2024 оны жилийн эцсийн байдлаар **5,516.0** сая төгрөгийн зээлийн үлдэгдэл байгаагаас **2,291.5** сая төгрөгийн зээл хэвийн төлөгдөж, **3,224.5** сая төгрөгийн зээл хугацаа хэтэрсэн байна.

Хугацаа хэтэрсэн зээл



Зээлийн ангилал






АУДИТААР ХҮРГҮҮЛСЭН ЗӨВЛӨМЖ:

Сангийн эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгох.

ХХСангийн зээл авсан төсөлд улирал тутам хяналт хийж, дүнг нийтэд мэдээлэх.

Хоршоог хөгжүүлэх сангийн зээлийн үлдэгдлийг төвлөрүүлэх ажлыг зохион байгуулах.



Сумдын хоршоог хариуцсан хүний нөөцийг бүрдүүлж, чадавхжуулах, мэргэжил арга зүйгээр хангах ажлыг зохион байгуулах

Аймгийн хоршоо хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг дунд хугацааны бодлоготой уялдуулан тогтоож, хэрэгжилтийг зохион байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллах

Төрөөс хоршоо, жижиг дунд үйлдвэр, үйлчилгээг хөгжүүлэх талаар баримталж буй бодлоготой уялдуулан хоршоог хөгжүүлэх сангийн үйл ажиллагааг нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангах ажиллах, үйл ажиллагааг олон нийтэд сурталчилах